

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2025/058/НА-СТА-ТШЗ

| | |
|-----------------------|--|
| Чингис хот 2025 он | Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn Аудитын менежер: Д.Оюунтуяа Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn Аудитор: Н.Хэрлэнбаяр Утас: 89051308 Цахим хаяг: kherlenbayarn@audit.gov.mn Цахим хаяг: www.audit.mn |
|-----------------------|--|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-12, Факс: 70-56-21-12

E-mail: khentii@audit.gov.mn

2025.02.25 № 295

танай _____ -ны № _____ -т

Г ХЭНТИЙ АЙМГИЙН ХЭРЛЭНБАЯН-УЛААН Г
ТОСГОНЫ ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Д.СОЛОНГО ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд улсын төсвөөс 650,443.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 47,100.0 мянган төгрөгийн санхүүжилт авч үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 394.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, үйл ажиллагаанд 603,017.9 мянган төгрөгийг зарцуулж, 4,571.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна. Анхан шатны баримтыг үндэслэн нягтлан бодох бүртгэлийг тухай бүр үнэн зөв хөтөлж, санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад анхаарч ажиллах шаардлагатай.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар 169,826.5 мянган төгрөгийн 7 алдаа, зөрчил илэрснээс 165,531.3 мянган төгрөгийн 5 алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулж, 668.7 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 3,626.5 мянган төгрөгийн зөрчилд 1 албан албан шаардлага хүргүүлээ.

232520295

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 10 зорилтын хүрээнд 82 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, 88.0 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан | | /Төгрөгөөр/ | |
|---|---|----------------------|----------------------|
| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 86,450,639.7 | 182,854,917.5 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 31,771,363.7 | 122,119,961.5 |
| 311 | Кассанд байгаа бэлэн мөнгө | - | - |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 31,771,363.7 | 122,119,961.5 |
| 3121 | Төгрөг | 31,771,363.7 | 122,119,961.5 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 31,771,363.71 | 122,119,961.48 |
| 33 | АВЛАГА | - | - |
| 34 | УРЬДЧИЛГАА | - | - |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 54,679,276.0 | 60,734,956.0 |
| 351 | Түүхий эд материал | 167,000.0 | 167,000.0 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 167,000.00 | 167,000.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | | |
| 354 | Хангамжийн материал | 54,512,276.0 | 60,567,956.0 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 546,000.0 | 546,000.0 |
| 35420 | Аж ахуйн материал | 28,552,484.5 | 33,772,384.5 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 2,347,500.00 | 4,524,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 8,566,500.00 | 6,433,600.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 14,499,791.47 | 15,291,971.47 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 335,830,047.4 | 423,587,128.6 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 335,830,047.4 | 423,587,128.6 |
| 392 | Биет хөрөнгө | 287,830,047.4 | 375,587,128.6 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 295,853,992.00 | 406,103,566.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (86,803,906.35) | (107,791,154.41) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 120,580,979.0 | 98,098,267.0 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (63,900,404.4) | (47,734,043.5) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хопшил | 29,698,248.2 | 35,113,248.2 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (13,331,444.0) | (14,855,866.6) |
| 39217 | Ном | 5,732,582.88 | 6,653,111.88 |
| 393 | Биет бус хөрөнгө | 48,000,000.00 | 48,000,000.00 |
| 39301 | Програм хангамж | 400,000.0 | - |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (400,000.0) | - |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 48,000,000.00 | 48,000,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 422,280,687.1 | 606,442,046.1 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | - | 7,184,800.0 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | - | 7,184,800.00 |
| 413 | Өглөг | - | 7,184,800.00 |
| 4136 | Бусад өглөг | - | 7,184,800.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 7,184,800.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 422,280,687.1 | 599,257,246.1 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 422,280,687.1 | 599,257,246.1 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 228,690,952.9 | 228,690,952.9 |
| 51101 | Өмч: - төрийн | 228,690,952.9 | 228,690,952.9 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 52,726,418.0 | 229,702,977.0 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 52,726,418.0 | 52,726,418.0 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 176,976,559.0 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 140,863,316.2 | 140,863,316.2 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 422,280,687.1 | 606,442,046.1 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан | | | /Төгрөгөөр/ |
|---|---|---------------------|-----------------------|
| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 429,473,851.47 | 812,928,728.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 24,989,951.47 | 115,385,328.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 24,989,951.47 | 115,385,328.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 24,989,951.47 | 115,385,328.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 359,700.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 35,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /Үндсэн хөрөнгө/ | 24,989,951.47 | 114,990,628.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 404,483,900.00 | 697,543,400.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 378,541,800.00 | 650,443,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 378,541,800.00 | 650,443,400.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 25,942,100.00 | 47,100,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт бай | 25,942,100.00 | 47,100,000.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 475,668,801.82 | 635,952,168.99 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 475,668,801.82 | 635,952,168.99 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 473,802,662.63 | 631,380,591.73 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 337,049,205.00 | 460,200,661.32 |
| 210101 | Үндсэн цалин | 326,570,006.01 | 409,360,168.32 |
| 210102 | Нэмэгдэл | 10,479,198.99 | 50,840,493.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 40,808,530.73 | 54,978,097.54 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 27,690,148.46 | 38,826,171.29 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,395,316.36 | 8,839,402.28 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,403,898.66 | 1,179,739.64 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 618,672.90 | 1,141,714.59 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,700,494.35 | 4,991,069.74 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 22,515,044.81 | 29,778,122.74 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,714,000.81 | 3,676,422.74 |
| 210302 | Түлш, халаалт | 17,959,500.00 | 25,723,700.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 841,544.00 | 378,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 1,991,960.00 | 1,932,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,219,300.00 | 1,932,000.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 772,660.00 | - |
| 2105 | Нормативт зардал | 18,946,710.00 | 28,952,420.00 |
| 210502 | Хоол, хүнс | 18,946,710.00 | 28,952,420.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 777,500.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 777,500.00 | - |
| 2107 | Томилолт, зочны зардал | - | 870,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 870,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 674,256.00 | 1,032,008.80 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний тө | 248,800.00 | - |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 425,456.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 1,032,008.80 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 51,039,456.09 | 53,637,281.33 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 15,968,200.00 | 8,353,614.57 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 32,400.00 | 1,884,300.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 35,038,856.09 | 43,399,366.76 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,866,139.19 | 4,571,577.26 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,660,240.00 | - |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 1,660,240.00 | 00.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, с | 205,899.19 | 4,571,577.26 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 205,899.19 | 4,571,577.26 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | (46,194,950.35) | 176,976,559.01 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 36,112,500.00 | 00.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 36,112,500.00 | 00.00 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | (36,112,500.00) | - |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | (82,307,450.35) | 176,976,559.01 |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|--|---------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 404,483,900.00 | 697,938,100.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | - | 394,700.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | - | 394,700.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | - | 394,700.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 359,700.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 35,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 404,483,900.00 | 697,543,400.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 378,541,800.00 | 650,443,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 378,541,800.00 | 650,443,400.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 25,942,100.00 | 47,100,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгуул | 25,942,100.00 | 47,100,000.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 460,568,199.57 | 607,589,502.23 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 460,568,199.57 | 607,589,502.23 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 448,385,280.38 | 592,556,774.97 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 333,416,438.76 | 457,563,413.52 |
| 210101 | Үндсэн цалин | 229,897,220.46 | 286,791,027.30 |
| 210102 | Нэмэгдэл | 90,229,717.56 | 157,376,988.95 |
| 210104 | Урамшуулал | 13,289,500.74 | 13,395,397.27 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 42,175,340.81 | 57,615,345.34 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 28,740,044.49 | 38,216,572.24 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,395,076.79 | 4,921,843.23 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,656,129.51 | 2,613,862.01 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 665,591.52 | 2,444,333.49 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,718,498.50 | 9,418,734.37 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 23,051,200.81 | 31,903,422.74 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,714,000.81 | 3,676,422.74 |
| 210302 | Түлш, халаалт | 18,855,000.00 | 27,849,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 482,200.00 | 378,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 21,322,540.00 | 16,321,370.00 |
| 210502 | Хоол, хүнс | 21,322,540.00 | 16,321,370.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,685,000.00 | 10,625,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,685,000.00 | 10,625,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,964,800.00 | 5,029,123.37 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлб | 574,800.00 | 359,700.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,390,000.00 | 4,669,423.37 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 23,769,960.00 | 13,499,100.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 21,685,260.00 | 11,614,800.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,084,700.00 | 1,884,300.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 12,182,919.19 | 15,032,727.26 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 11,977,020.00 | 10,461,150.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 11,977,020.00 | 10,461,150.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санх | 205,899.19 | 4,571,577.26 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 205,899.19 | 4,571,577.26 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | (56,084,299.57) | 85,777,020.51 |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | (56,084,300) | 85,777,020.51 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 31,771,363.71 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 31,771,363.71 | 122,119,961.48 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан | | | | |
|---|---------------------------------|-----------------------|-------------------|--|
| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | / төгрөгөөр / Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
| 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 228,690,952.90 | 140,863,316.16 | 52,726,418.01 | 422,280,687.07 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 228,690,952.90 | 140,863,316.16 | 52,726,418.01 | 422,280,687.07 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | - | - |
| 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 228,690,952.90 | 140,863,316.16 | 52,726,418.01 | 422,280,687.07 |
| 2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 228,690,952.90 | 140,863,316.16 | 52,726,418.01 | 422,280,687.07 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 228,690,952.90 | 140,863,316.16 | 52,726,418.01 | 422,280,687.07 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 176,976,559.01 | 176,976,559.01 |
| 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 228,690,952.90 | 140,863,316.16 | 229,702,977.02 | 599,257,246.08 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан | | | | | / төгрөгөөр / |
|---|--|-----------------------|----------------|----------------|---------------|
| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | - |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 729,673,400.00 | 603,017,924.97 | 126,655,475.03 | |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 729,673,400.00 | 603,017,924.97 | 126,655,475.03 | |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 718,106,300.00 | 592,556,774.97 | 125,549,525.03 | |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 548,559,800.00 | 457,563,413.52 | 90,996,386.48 | |
| 210101 | Үндсэн цалин | 359,580,500.00 | 283,086,137.30 | 76,494,362.70 | |
| 210102 | Нэмэгдэл | 177,689,500.00 | 161,081,878.95 | 16,607,621.05 | |
| 210104 | Урамшуулал | 11,289,800.00 | 13,395,397.27 | (2,105,597.27) | |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 68,570,200.00 | 57,615,345.34 | 10,954,854.66 | |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 46,627,600.00 | 38,216,572.24 | 8,411,027.76 | |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,485,600.00 | 4,921,843.23 | 563,756.77 | |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,742,900.00 | 2,613,862.01 | 129,037.99 | |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,742,900.00 | 2,444,333.49 | 298,566.51 | |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,971,200.00 | 9,418,734.37 | 1,552,465.63 | |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 36,475,000.00 | 31,903,422.74 | 4,571,577.26 | |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,200,000.00 | 3,676,422.74 | 1,523,577.26 | |
| 210302 | Түлш, халаалт | 30,775,000.00 | 27,849,000.00 | 2,926,000.00 | |
| 210303 | Цэвэр, бохир ус | 500,000.00 | 378,000.00 | 122,000.00 | |
| 2105 | Нормативт зардал | 34,946,000.00 | 16,321,370.00 | 18,624,630.00 | |
| 210502 | Хоол, хүнс | 34,946,000.00 | 16,321,370.00 | 18,624,630.00 | |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 10,625,000.00 | 10,625,000.00 | - | |
| 210604 | Урсгал засвар | 10,625,000.00 | 10,625,000.00 | - | |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 5,230,300.00 | 5,029,123.37 | 201,176.63 | |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээ | 359,700.00 | 359,700.00 | - | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,870,600.00 | 4,669,423.37 | 201,176.63 | |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 13,700,000.00 | 13,499,100.00 | 200,900.00 | |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,815,700.00 | 11,614,800.00 | 200,900.00 | |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,884,300.00 | 1,884,300.00 | - | |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 11,567,100.00 | 10,461,150.00 | 1,105,950.00 | |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 11,567,100.00 | 10,461,150.00 | 1,105,950.00 | |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 11,567,100.00 | 10,461,150.00 | 1,105,950.00 | |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 729,673,400.00 | 693,366,522.74 | 36,306,877.26 | |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 650,443,400.00 | 650,443,400.00 | - | |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 650,443,400.00 | 650,443,400.00 | - | |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 47,100,000.00 | 42,528,422.74 | 4,571,577.26 | |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 47,100,000.00 | 42,528,422.74 | 4,571,577.26 | |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 32,130,000.00 | 394,700.00 | 31,735,300.00 | |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 359,700.00 | 359,700.00 | - | |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 35,000.00 | (35,000.00) | |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 31,770,300.00 | | 31,770,300.00 | |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 31,771,363.71 | | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 122,119,961.48 | | |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1.00 | 1.00 | - | |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 | - | |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 19.00 | 19.00 | - | |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - | |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 10.00 | 10.00 | - | |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 5.00 | 5.00 | - | |
| 620004 | Гэрээт ажилтан | 3.00 | 3.00 | - | |
| 63 | СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР) | 63.00 | 63.00 | - | |
| 630 | ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛ | 63.00 | 63.00 | - | |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 63.00 | 63.00 | - | |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 19.00 | 19.00 | - | |
| 650004 | ССБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБ) | 11.00 | 11.00 | - | |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 5.00 | 5.00 | - | |
| 650010 | Гэрээт ажилтан | 3.00 | 3.00 | - | |

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 165,531.3 мянган төгрөгийн 5 алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

1. Тайлант хугацааны элэгдлийн зардлыг 16.8 сая төгрөгөөр дутуу тооцон санхүүгийн тайланд тусгасан.
2. Сургуулийн дотуур байрны барилгад хийсэн их засварын ажлын 110.2 сая төгрөгийг барилгын өртөгт капиталжуулахгүй тусад нь дотуур байрны их засвар нэрээр орлогод авч бүртгэсэн.
3. Гэрээний дагуу хүлээн авсан 9,8 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлсэн урьдчилгаа төлбөр болох 2.7 сая төгрөгөөр орлогод авч бүртгэлд тусгасан.
4. Бараа материалыг орлогод авалгүй 3,626.5 мянган төгрөгийг шууд зардлын дансанд бүртгэсэн.
5. Тайлант хугацааны 5,512.5 мянган төгрөгийн элэгдлийн зардал, 15.5 сая төгрөгийн хүнсний материалын зардал, 5,865.0 мянган төгрөгийн халаалтын зардал, 870.0 мянган төгрөгийн томилолтын зардлыг зардлын эдийн засгийн ангилал зөрүүлэн бүртгэсэн.

Аудитаар нийт 4,295.3 мянган төгрөгийн 2 зөрчил¹ илэрснээс, 668.7 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 3,626.5 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн.

5.1 Төлбөрийн акт

1. Ээлжийн амралттай ажилтанд 668.7 мянган төгрөгийн цалин давхардуулан олгосон.

5.2 Албан шаардлага

1. Бараа материалыг орлогод авалгүй 3,626.5 мянган төгрөгийг шууд зардлын дансанд бүртгэсэн.

5.3 Зөвлөмж

Байхгүй.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|--|------------|------------------|-----------------------------------|-----|--------------------------|------------------|------------|------------------|--------------|-----|---------|-----|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Элэгдлийн зардлыг дутуу тооцон | 1 | 16,841.8 | | | 1 | 16,841.8 | 1 | 16,841.8 | | | | |
| Их засварын ажлыг капиталжуулаагүй | 1 | 110,249.6 | | | 1 | 110,249.6 | 1 | 110,249.6 | | | | |
| Өр төлбөрийг бүртгэлд тусгаагүй. | 1 | 7,143.8 | | | 1 | 7,143.8 | 1 | 7,143.8 | | | | |
| Эдийн засгийн ангилал сольж бүртгэсэн. | 1 | 3,545.5 | | | 1 | 3,545.5 | 1 | 3,545.5 | | | | |
| Эдийн засгийн ангилал сольж бүртгэсэн. | 1 | 27,750.5 | | | 1 | 27,750.5 | 1 | 27,750.5 | | | | |
| Дүн | 5 | 165,531.3 | | | 1 | 165,531.3 | 1 | 165,531.3 | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|--------------------------------------|-------------|----------------|---------------|--------------|-----------------|----------------|---------|-----|--------------------------------------|---------------------|---|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Үндэслэлгүй цалин олгосон | 1 | 668.7 | 1 | 668.7 | | | | | | | | |
| Бараа материалыг шууд зардалд хаасан | 1 | 3,626.5 | | | 1 | 3,626.5 | | | | | | |
| Дүн | 2 | 4,295.3 | 1 | 668.7 | 1 | 3,626.5 | | | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|--|-------------|-------------|---------------|-------------|-----------------|-------------|----------|-------------|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | 0 | 0,00 | 0 | 0,00 | 0 | 0,00 | 0 | 0,00 |

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|-----------------------------|--------------------------|-----------------------------|--------------------|-----------------|-------------------------|----------------|-------|----------------------------|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | | | | |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| 2 | Төсөл, хөтөлбөр | | | | | | | | |
| 3 | ЗГТС | | | | | | | | |
| 4 | ТТЗ | | | | | | | | |
| 5 | ТЕЗ | | | | | | | | |
| | НИЙТ | 1 | 1 | | | 1 | | | |



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 99-ХЭА-2025/058/НА-СТА-ТШЗ
А 2371281 Чингис хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 6 ажилтны ээлжийн амралтыг биеэр эдлүүлээгүй 668.7 мянган төгрөгийн цалинг ээлжийн амралтын олговортой давхардуулан тооцож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1-т "Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно." гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-д "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэсэн заалтыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Давхардуулан тооцож олгосон цалингийн 668.7 мянган төгрөгийг аймгийн Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Ерөнхий боловсролын сургуулийн захирал Д.Солонго, нягтлан бодогч М.Хангай нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ж.ГАНБААТАР

Н.ХЭРЛЭНБАЯР





ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 дугаар сарын 23

Дугаар 111-ХЭА-2025/058/НА-СТА-ТШЗ
А 2371281 Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймагийн Хэрлэнбаян-Улаан тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 3.6 сая төгрөгийн бараа материалыг орлогод авч дэлгэрэнгүй тайланд бүртгэлгүй шууд зарлагдаж, нягтлан бодох бүртгэлийг зохих ёсоор хөтлөөгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т "Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-т "Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Бараа материалыг дэлгэрэнгүй тайланд бүртгэлгүй шууд зардалд хаадаг зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хэрлэнбаян-Улаан тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн захирал Д.Солонго, нягтлан бодогч М.Хангай нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР

Ж.ГАНБААТАР
Н.ХЭРЛЭНБАЯР



232504111